

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2024 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: Nazgul.D@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
НИСЭХ БУУДЛЫН ДАРГА К.ЕРЖАН
ТАНАА

2024.03.12 № 337
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402338

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	12,763,839.53	42,187,549.52
1.1.2	Дансны авлага	11,462,276.49	4,325,782.04
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	53,500.01	926,366.56
1.1.4	Бусад авлага		873,400.00
1.1.6	Бараа материал	119,737,237.37	129,097,647.93
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	144,016,853.40	177,410,746.05
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,264,143,524.01	8,490,832,953.14
1.2.2	Биет бус хөрөнгө	7,321,647,942.14	7,303,990,883.78
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	40,072,933.18	29,562,299.30
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,625,864,399.33	15,824,386,136.22
<u>1.3</u>	<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u>	<u>16,769,881,252.73</u>	<u>16,001,796,882.27</u>
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3	Татварын өр	32,246.40	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		3,711.10
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	32,246.40	3,711.10
2.2	Өр төлбөрийн нийт дүн	32,246.40	3,711.10
2.3	Эздийн өмч	8,339,269,996.91	8,156,780,413.43
2.3.1	Өмч: - төрийн	7,284,500,000.00	7,284,500,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,054,769,996.91	872,280,413.43
2.3.9	Хуримтлагдсан ашиг	8,430,579,009.42	7,845,012,757.74

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Эздийн өмчийн дүн	16,769,849,006.33	16,001,793,171.17
2.4	<u>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</u>	<u>16,769,881,252.73</u>	<u>16,001,796,882.27</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	23,032,060.96	45,780,359.68
2	Борлуулалтын өртөг	1,705,702,906.15	2,085,537,901.79
3	Нийт ашиг(алдагдал) /1-2/	-1,682,670,845.19	-2,039,757,542.11
5	Хүүгийн орлого		231,358.56
8	Бусад орлого	1,678,476,981.42	1,355,492,368.42
10	Ерөнхий ба удирдлагын зардал	800,000.00	900,000.00
12	Бусад зардал	96,277,854.36	83,122,020.03
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-101,271,718.13	-768,055,835.16
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-101,271,718.13	-768,055,835.16
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-101,271,718.13	-768,055,835.16
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-101,271,718.13	-768,055,835.16

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	7,284,500,000.00	1,054,769,996.91	8,430,579,009.42	16,769,849,006.33

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Залруулсан үлдэгдэл	7,284,500,000.00	1,054,769,996.91	8,430,579,009.42	16,769,849,006.33
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	-768,055,835.16	-768,055,835.16
4	Өмчид гарсан өөрчлөлт	0	-182,489,583.48	182,489,583.48	
5	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	7,284,500,000.00	872,280,413.43	7,845,012,757.74	16,001,793,171.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		0
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,106,660,536.66	1,301,327,980.50
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	19,443,536.66	56,193,780.50
	Татаас, санхүүжилтийн орлого	1,087,217,000.00	1,245,134,200.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,108,840,417.58	1,269,185,629.07
	Ажиллагчдад төлсөн	612,165,097.55	644,680,999.43
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	165,294,562.37	181,933,783.30
	Бараа материал худалдан авахад төлсөн	193,964,453.46	272,721,010.72
	Ашиглалтын зардалд төлсөн	33,518,464.40	61,717,199.78
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,850,000.00	0.00
	Хүүгийн төлбөрт төлсөн	0.00	23,135.84
	Татварын байгууллагад төлсөн	91,763,140.00	92,234,100.00
	Даатгалын төлбөрт төлсөн	6,898,300.00	7,898,400.00

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Бусад мөнгөн зарлага	1,386,399.80	7,977,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,179,880.92	32,142,351.43
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	231,358.56
	Хүлээн авсан хүүгийн орлого	0	231,358.56
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	2,950,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0	2,950,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	-2,718,641.44
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-2,179,880.92	29,423,709.99
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,943,720.45	12,763,839.53
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,763,839.53	42,187,549.52

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Мянган төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны тодотгол	2023 оны тодотгол	2023 оны гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт	Хувь
НИЙТ ЗАРЛАГА	1,344,251.40	1,355,851.30	1,267,185.1		
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	1,344,251.4	1,355,851.3	1,267,185.1	88,666.2	93.5
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,326,841.40	1,338,222.70	1,258,600.7	79,622.0	94.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	820,298.30	817,290.40	738,538.8	78,751.6	90.4
Үндсэн ба нэмэгдэл цалин	726,281.30	702,739.30	626,683.81	76,055.5	89.2
Унаа хоолны хөнгөлөлт	94,017.00	90,551.10	87,855.00	2,696.1	97.0
Гэрээт ажлын цалин		24,000.00	24,000.0	-	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,537.20	107,713.60	99,182.30	8,531.3	92.1
Тэтгэврийн даатгал	69,725.40	69,469.70	63476.67	5,993.0	91.4
Тэтгэмжийн даатгал	8,204.80	8,172.90	7141.13	1,031.8	87.4

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ҮОМШ-ийн даатгал	6,562.40	12,090.60	11108.42	982.2	91.9
Ажилгүйдлийн даатгал	1,640.60	1,634.60	1586.92	47.7	97.1
Эрүүл мэндийн даатгал	16,404.00	16,345.80	15869.17	476.6	97.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,434.30	64,791.90	60,677.2	4,114.7	93.6
Гэрэл, цахилгаан	15,660.00	23,315.10	19,210.20	4,104.9	82.4
Түлш, халаалт	30,791.80	39,327.10	39,327.00	0.1	100.0
Цэвэр, бохир ус	1,982.50	2,149.70	2,140.00	9.7	99.5
Хангамж, бараа материалын зардал	75,602.60	83,536.80	84,502.6	(965.8)	101.2
Бичиг хэрэг	1,144.30	1,380.40	1,175.30	205.1	85.1
Тээвэр, шатахуун	59,949.50	63,912.80	68,488.85	(4,576.1)	107.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,127.90	5,978.70	5,701.35	277.3	95.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,165.40	7,803.50	4,726.95	3,076.6	60.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,215.50	4,461.40	4,410.10	51.3	98.9
Нормативт зардал	17,860.00	-	0.0	-	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,860.00	-	0.00	-	-
Эд хогшил, урсгал засварын зардал	127,978.50	95,250.10	100,935.4	(5,685.3)	106.0
Багаж, техник, хэрэгсэл	87,713.50	41,506.50	37,893.0	3,613.5	91.3
Тоног төхөөрөмж	36,901.70	13,960.80	10,429.63	3,531.2	74.7
Автомашин	9,044.30	6,204.90	6,204.03	0.9	100.0
Аэродром	13,202.50	7,743.70	7,725.35	18.3	99.8
Гал унтраах зардал	28,565.00	13,597.10	13,534.00	63.1	99.5
Хөдөлмөр хамгааллын зардал	11,200.00	29,881.30	29,853.55	27.8	99.9
Урсгал засвар	29,065.00	23,862.30	33,188.82	(9,326.5)	139.1
Томилолт, зочны зардал	25,000.00	30,646.00	40,912.4	(10,266.4)	133.5
Дотоод албан томилолт	25,000.00	30,646.00	40,912.41	(10,266.4)	133.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,130.50	138,993.90	133,852.1	5,141.8	96.3

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		19,800.00	19,800.0	-	
Харуул, хамгаалалтын зардал	9,100.00	9,100.00	8,844.60	255.4	97.2
Холбооны суваг ашигласны хөлс		3,804.00	3,802.80	1.2	
Үл хөдлөх хөрөнгийн татвар	77,012.80	79,852.10	77,409.60	2,442.5	96.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	810.00	887.2	900.00	(12.8)	101.4
Даатгалын үйлчилгээ	6,898.30	7,898.40	7,898.40	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	597.40	904.1	526.90	377.2	58.3
Газрын төлбөр	14,568.00	16,572.10	14,569.00	2,003.1	87.9
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	144.00	176	100.80	75.2	57.3
Бараа үйлчилгээний бусад зардал	6,700.0	6,393.6	5,689.9	703.7	89.0
Бараа үйлчилгээний бусад зардал	5,700.00	4,993.60	5,259.93	(266.3)	105.3
Сургалт семинар	1,000.0	1,400.0	430.0	970.0	30.7
Дотоод сургалт	1,000.00	1,400.00	430.00	970.0	30.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,710.0	11,235.0	2,894.5	8,340.6	25.8
	112,290.00	50,470.00	4,304.5	46,165.6	8.5
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	10,710.0	11,235.0	2,894.5	8,340.6	25.8
Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж	9,225.00	9,750.00	1,410.00	8,340.0	14.5
Эмчилгээний төлбөр	1,485.0	1,485.0	1,484.45	0.5	100.0

НИЙТ ОРЛОГЫН ДҮН	90,870.0	28,000.0	56,158.8	(28,158.8)	200.6
Агаарын навигацийн үйлчилгээний орлого	-	-	-	-	
Буулт, хөөрөлтийн орлого	20,220.0	18,000.00	56,158.78	(38,158.8)	312.0
Зорчигч үйлчилгээний орлого	16,750.0	4,500.00	-	4,500.0	-
Бусад орлого	53,900.0	5,500.00	-	5,500.0	-

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудал нь аймаг, нийслэлийг холбосон агаарын зайд эдийн засгийн үр ашигтай агаарын навигацийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, удирдан чиглүүлэх, зохион байгуулалтаар хангах үйл ажиллагаа явуулдаг Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Нисэх буудал тайлант онд “Нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг найдвартай хангаж, үйлчлүүлэгчдийг дээдэлсэн чанартай, соёлтой, тав тухтай үйлчилгээ үзүүлэх” зорилгын хүрээнд “Иргэний нисэхийн зорилтот тогтолцоог бүрдүүлж, аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг хэрэгжүүлэх, үйлчлүүлэгчдийг дээдэлсэн аюулгүй эрүүл тохилог, үр ашигтай ажиллах” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Нисэх буудал нь Иргэний нисэхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Нисэх буудлын үйл ажиллагаанд Иргэний нисэхийн Ерөнхий газрын дотоод аудитын газраас хяналт шалгалт хийдэг ба 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Иргэний нисэхийн Ерөнхий газрын даргын 2021 оны А/124 тоот тушаалаар шинэчлэн баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 768.1 сая төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,763.84	42,187.55	29,423.71
Авлага	11,515.78	6,125.55	-5,390.23
Бараа материал	119,737.24	129,097.65	9,360.41
Үндсэн хөрөнгө	16,625,864.40	15,824,386.14	-801,478.26
Нийт хөрөнгө	16,769,881.25	16,001,796.88	-768,084.37
Өр төлбөр	32.25	3.71	-28.54
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	16,769,849.01	16,001,793.17	-768,055.84
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,769,881.25	16,001,796.88	-768,084.37

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө данс 42.2 сая төгрөг болж оны эхнээс 29.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлага дансанд оны эхэнд үйлчилгээний орлогын 11.5 сая, нэмэгдсэн өртгийн албан татварын 0.05 сая, нийт 11.5 сая төгрөгийн авлагатай байсан ба үйлчилгээний орлогын авлага 7.2 сая төгрөгөөр буурч, нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 0.9 сая, бусад авлага 0.8 сая төгрөгөөр нэмэгдэж оны эцэст нийт 6.1 сая төгрөгийн авлагатай байна.

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материал данс оны эцэст 129.1 сая төгрөг болж оны эхнээс 9.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Бараа 57.9 сая, түлш шатахуун 26.5 сая, сэлбэг хэрэгсэл 2.3 сая, бусад бараа материал 42.3 сая төгрөг байна. Их хэмжээгээр бараа материал нөөцлөөгүй байна.

Үндсэн хөрөнгө данс 15,824.4 сая төгрөг болж оны эхнээс 801.5 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд үндсэн хөрөнгө 164.6 сая төгрөгөөр нэмэгдэж, байгуулсан 855.8 сая төгрөгийн элэгдэл, дотоод хөдөлгөөнөөр нэмэгдсэн 82.1 сая, нийт 937.9 сая төгрөгийн элэгдлийн хэмжээгээр буурсан байна. Элэгдлээ бүрэн нөхсөн 14.0 сая төгрөгийн 1 тээврийн хэрэгслийг хоорондын тооцоогоор систем хооронд шилжүүлсэн байна.

Өр төлбөр данс оны эхэнд 0.03 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг барагдуулсан байна.

Эздийн өмч данс 16,001.8 сая төгрөг болж, оны эхнээс 768.1 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Өлгий Нисэх буудлын тайлант онд батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөө буюу орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2.5-д хавсаргав.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Иргэний нисэхийн Ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн тушаалаар тус аймаг дахь “Өлгий” нисэх буудлын 2023 оны орлого, зардлын төлөвлөгөөг, 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн тушаалаар 2023 оны орлого, зардлыг төлөвлөгөөг тодотгож баталсан байна.

Тайлант онд тодотгосон нийт орлогыг 28.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,355.9 сая төгрөгөөр, 1,327.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 56.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,267.2 сая төгрөгийн зардал гарган, 1,211.0. сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 56.2. сая төгрөг болж төлөвлөснөөс 28.2 сая төгрөг буюу 100 хувиар давсанаас шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 1,267.2. сая төгрөг болж, төлөвлөснөөс 88.7 сая төгрөг буюу 7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалингийн зардлыг 78.8 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 8.5 сая, байр, ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 4.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 5.1 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.7 сая, сургалт семинарын зардлыг 1.0 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 8.3 сая, нийт 107.3 сая төгрөгөөр хэмнэж, хангамж бараа материалын зардлыг 1.0 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 5.7 сая, урсгал засварыг 9.3 сая, томилт, зочны зардлыг 10.3 сая, нийт 26.3 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант оны алдагдал 1,211.0. сая төгрөг болж, төлөвлөснөөс 116.9. сая төгрөгөөр бага гарсан нь орлогын төлөвлөгөө давж биелсэн, батлагдсан зардлыг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудал, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайлангаа аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2022 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 1,108.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан зардлын төлөвлөгөөг 88.7 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд 104.2 сая төгрөгийн 2 тендерийн шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,301.5 сая төгрөгийн, зарлагын 178.6 сая төгрөгийн 19 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 23.9 сая төгрөгийн 5 шийдвэрийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹, зөрчил² илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

											шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								